

## МОНГОЛ АЛТАЙД ИЛЭРСЭН “СЭЛЭНГИЙН ХЭЛБЭР”-ИЙН ЗОСОН ЗУРАГ

(Говь-Алтай аймаг, Тонхил сум)

Ц. Төрбат<sup>1,\*</sup>, О. Нэргүй<sup>2</sup>, Б. Лхагвадорж<sup>3</sup>

**Товч агуулга:** Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт Алтайн нурууны урд биед байх Дунд Хулдын голын хөндийд Чойлонгийн гармын дэргэд байх нэгэн ханан хаданд “Сэлэнгийн хэлбэрийн” хадны зураг илэрчээ. Зосон зургууд нь хоёр бүлгээс бүрдэх бөгөөд хос гурвалжин бүхий нэгдүгээр бүлэг холбогдох соёл, он цаг нь баттай биш бол хос зураас, мал амьтад, хүн, дөрвөлжин хүрээ бүхий хоёрдугаар бүлэг нь хожуу хүрэл, түрүү төмрийн үед хамаарах Дөрвөлжин булшны соёлын зураг дүрслэл мөн юм. Мөн эдгээрийн ойролцоо сийлбэрлэх аргаар бүтээсэн дөрвөн бугын дүрслэл байх нь Хиргисүүр, буган хөшөөний соёлд хамаарах ажээ. Энэхүү зосон зураг нь одоогоор Дөрвөлжин булшны соёлд хамаарах “Сэлэнгийн хэлбэрийн” хадны зургийн хамгийн баруун захад байгаа тул судалгааны ач холбогдолтой юм.

**Түлхүүр үг:** “Сэлэнгийн хэлбэр”-ийн хадны зураг, хожуу хүрлийн үе, түрүү төмрийн үе, хадны зураг, зосон зураг, Монгол, Алтай

### Удиртгал

2021 оны 7-р сард Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт Урд Хулдын голын Шадатын бэлчирт ажилласан Ц.Төрбат, Б.Цэлхагарав, Д.Батсүх, О.Нэргүй нарын бүрэлдэхүүнтэй археологийн судалгааны баг үндсэн судалгаагаа Хэмцэгийн соёлын хүн чулуу бүхий зан үйлийн байгууламжийг малтахад чиглүүлсэн боловч боломжийг ашиглан орчны археологийн дурсгалуудыг үзэж танилцах, бүртгэн баримтжуулах чиглэлд анхаарал тавьсан болно. Энэ сонирхлын хүрээнд Хөх булгийн алганы улаан зосон зургуудыг баримтжуулан аваад судалгааны үр дүнг өгүүлэл болгон бичиж сэтгүүлийн энэ дугаарт нийтэлж байна. Мөн Урд Хулдын голын баруун талаар зэрэгцээ урсдаг Дунд Хулдын голоор МУБИС-ийн түүхийн ангийн төгсөгч, Говь-Алтай аймгийн төвийн арван жилийн 4-р сургуулийн багш Б.Лхагвадоржийн замчилан дагуулснаар Ц.Төрбат, О.Нэргүй нар аялж археологийн дурсгалуудтай танилцан явсан билээ. Энэ аялалын явцад бид Дунд Хулдын голын дунд урсгалд Чойлонгийн гэгддэг гармын дэргэд байх нэгэн ханан хадны бэлд хадны зургийн дурсгалыг олж илрүүлэв.

Хээрийн шороон замаар зорчин явахад энэхүү боржин чулуун ханан хадны нүүрэн талд буй сийлмэл

бугын дүрсүүд тодхон харагдана. Эдгээр зургийг очиж үзэх үед өөр нэг бүлэг зураг илэрсэн юм. Энэ бол улаан зосоор үйлдсэн “Сэлэнгийн” хэлбэрийн бүлэг зураг ба хос гурвалжингийн зосон зураг байлаа.

Бид “Сэлэнгийн” хэлбэрийн зургуудын тархац Төв ба Умард Монголоор хязгаарлагдаагүй мэдэх тул ихэд сонирхон гэрэл зургаар баримтжуулан авч зохих харьцуулалт хийн судалж энэхүү өгүүлэлд нийтэлж байна. Уг зосон зургийн ач холбогдлыг бидний Урд Хулдын голын Шадатын бэлчирт малтсан дөрвөлжин булш улам тодосгон өгч байгаа бөгөөд Дөрвөлжин булшны соёлын нэгэн төв Монгол Алтайн нурууны урд бэлд байжээ гэдэг нь харагдаж байгаа болно.

### Дунд Хулдын зосон зураг

Дунд Хулдын голын зосон зураг «Сэлэнгийн» хэлбэрийн олонхи зургуудаас харьцангуй жижиг бөгөөд ганц өгүүлэмжийг хоёр цөм дүрслэлийн хэмжээнд зурсан байна. Үүний зэрэгцээ хос гурвалжин дүрсийг зосоор зурсан байгаа нь өвөрмөц дүрслэл болно.

Нэгдүгээр бүлэг буюу хос гурвалжин. Дунд Хулдын зосон зургийн дурсгалд илэрсэн хос гурвалжин нь Монголын хадны зургийн дотор тохиолдож байгаагүй өвөрмөц дүрслэл юм (Зураг 3). Дээд талын гурвалжин нь дээшээ харсан цул гурвалжин бөгөөд нэлээд шовх оройтой ажээ. Харин доодох гурвалжин нь урвуу бөгөөд зөвхөн хүрээлэн зурсаны дээр суурь нь задгай ажээ.

Хоёрдугаар бүлэг буюу “Сэлэнгийн” хэлбэрийн өгүүлэмж. Сонгодог хос цөмт зургийн өгүүлэмж нь

<sup>1</sup> МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

\* Холбоо барих зохиогч: [turbat.ts@num.edu.mn](mailto:turbat.ts@num.edu.mn)  
<https://orcid.org/0000-0001-6606-8516>

<sup>2</sup> Говь-Алтай аймгийн музей

<sup>3</sup> Говь-Алтай аймгийн Алтай хотын ерөнхий боловсролын 4-р сургууль



*Зураг 1. Дунд Хулдын голын Чойлонгийн хадны зураг бүхий ханан хад (Гэрэл зургийг О.Нэргүй, 2021 он)*




*Зураг 2. Дунд Хулдын Чойлонгийн хадны сийлбэр зураг. Баруун гар талд нэг, харин зүүн гар талд хоёр бугын дүрслэл байна (Гэрэл зургийг О.Нэргүй, 2021 он)*

хос зураас ба түүний дээд доор талд буй хүн амьтад, дөрвөлжин хүрээ ба түүний дотор ба дээд доод талд буй хүн амьтдын дүрслэлээс бүрдэнэ (Зураг 4-5).

Хос зураасны дээд талын 5 дүрс нь нэгэн хүнээр эхэлсэн 3 том дэлдэн чихтэй амьтны зүүн гар тийш хандсан цуваа байна. Тэдгээрийн доор хос зураас байх бөгөөд баруун гар талын үзүүрт нь нэгэн хүний дүрс бий. Зураасны доор толгойг нь уруу харуулсан өөр нэгэн жагсаал байна. Энд мөн л нэгэн хүнээр эхлэх бөгөөд араас нь 3 том дэлдэн чихтэй гурван амьтан зүүн гар тийш цуварчээ. Хос зураасны хоёр талд байх хүн амьтдын дүрс толины тусгал мэт адил тоотой бөгөөд байрлалтай байгааг анхаарах нь зүйтэй.

Нөгөөх цөм дүрслэл нь дөрвөлжин хүрээ ба түүний дотор жагсан зогссон 5 хүний дүрс, тэдгээрийн хөлд хэвтээ байдалтай толгойгоо баруун гар тал руу хандуулсан нэгэн хүн, түүний эсрэг талд муу хадгалагдсан боловч мөн адил хүний дүрс байгаа бололтой. Тэр хоёрын завсар хооронд чамдманласан гурван цэг бий. Хүрээний дээр баруун гар тийш цуварсан 4 амьтан байхын чихийг дүрслээгүй байна. Хүрээний доор гараа алдалсан 2 хүний дүрс ба цуварсан гурван цэг байх ажээ.



Зураг 3. Дунд Хулдын зосон зургийн нэгдүгээр бүлэг. Хос гурвалжин дүрс. А- оригинал гэрэл зураг, В- “DSStretch” программаар өнгө шүүсэн зураг (Гэрэл зургийг О.Нэргүй, 2021 он)



Зураг 4. Дунд Хулдын зосон зургийн хоёрдугаар бүлэг (Гэрэл зургийг О.Нэргүй, 2021 он)



Зураг 5. Зураг 4. Дунд Хулдын зосон зургийн  
хоёрдугаар бүлгийн гар зураг (Гар зургийг  
Ц.Төрбат, 2021 он)

### Хэлэлцүүлэг

Монголын зосон зураг болон хожуу хүрэл-түрүү төмрийн үеийн хадны зургийн дотор чухал байр суурийг эзэлсэн өвөрмөц нэгэн төрлийн зургийн уламжлал бол “Сэлэнгийн” хэлбэрийн гэж нэрлэгдсэн зураг юм. Энэ нэр томъёог анх 1949 онд А.П.Окладников гаргажээ (Окладников 1949: 10). Түүгээр зогсохгүй тэрээр “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургууд он цаг ба соёлын хувьд Дөрвөлжин булштай холбоотой болохыг ч анх тодорхойлсон юм.

“Сэлэнгийн” хэлбэрийн хадны зургийн дүрүүд, өгүүлэмжүүд, дүрслэлийн арга техникийг олон судлаачид сайн тодорхойлон бичсэн бөгөөд одоо шинээр нэмэх зүйл бараг байхгүй юм. Харин утга агуулгын талаар мэтгэлцээн үргэлжилсээр байгаа талаар судалгааны тойм бүтээлүүд нэгэнт олонтоо бичигдсэнээс сүүлийн үеийн цөөн зохиолыг дурдая (Амартүвшин 2002; Цыбиктаров 2011; Даваацэрэн 2017; Ponomareva 2020). Өвөр Байгал ба Монголд хийгдсэн судалгаануудын тойм, ялангуяа утга агуулгын мэтгэлцээний талаар Ч.Амартүвшин, Б.Даваацэрэн, В.А.Цыбиктаров, И.А.Пономарева нарын дээрх бүтээлүүдээс дэлгэрэнгүй үзэж болно.

В.А.Цыбиктаровын шүүж үзсэнээр бол Өвөр Байгалд 2012 оны байдлаар “Сэлэнгийн” хэлбэрийн 85 зосон зургийн дурсгал байгаа ажээ (Цыбиктаров 2011: 196, 223). Харин Б.Даваацэрэнгийн шүүж нэгтгэсэн Монголд илрээд байгаа улаан зосон зургийн 72 дурсгал (Даваацэрэн 2017) дотроос ялган харахад дотор “Сэлэнгийн” хэлбэрийн хадны зургийн дурсгал 32 байгаа байгаа бололтой. Дээрхээс үзэхэд одоогоор “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн 157 дурсгал Монгол ба ОХУ-ын нутагт илрээд байна. Үүний дээр 7 дөрвөлжин булшны хашлага чулуун дээр сийлбэрлэсэн зургуудыг (Болдбаатар 2017) нэмбэл 164 дурсгал болж байгаа юм. Энэ бол тооны хувьд жинтэй төлөөлөл мөн бөгөөд “Сэлэнгийн” хэлбэрийн хадны зургийн тархалт ба байрлал зүй, үйлдсэн техник, дүр дүрслэл, утга агуулгыг хангалттай хэмжээнд тодорхойлон бичих бололцоо бүрдсэн гэж үзэж болох бөгөөд өмнөх үеийн судлаачид дээрх зорилтуудыг биелүүлж чаджээ. Гэхдээ жижиг онцлогууд, цөөн онцгой дүр ба дүрслэлүүд илэрсээр байж болохыг Дунд Хулдын зосон зургийн дурсгал харуулж байна.

“Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн тархалтын хүрээг 1970 онд А.П.Окладников, В.Д.Запорожская нар анх тодорхойлсноос хойш нэлээд тогтвортой

байсан боловч бидний илрүүлэн олж нийтэлж буй энэхүү дурсгалаас шалтгаалан өөрчлөгдөхөөр болж байна. “Сэлэнгийн” хэлбэрийн зургуудын тархалтын хүрээ нь зөвхөн ийм төрлийн зургийн асуудал биш илүү өргөн агуулгатай юм. Учир нь энэ төрлийн зургууд дөрвөлжин булштай холбоотой болох нь маргаангүй зүйл билээ. Иймээс “Сэлэнгийн” хэлбэрийн зураг байгаа тохиолдолд дөрвөлжин булсныхан тухайн нутагт оршин суусан гэсэн үг болно.

Өвөр Байгалд тархсан “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургууд гол төлөв Сэлэнгэ мөрний хөндийд төвлөрч тархсан байх зэрэгцээ баруун тийшээ Зэд (Жида) гол, зүүн тийшээ Үд (Уда) голын хөндийгөөс хэтэрдэггүй ажээ (Окладников, Запорожская 1970: 63-65).

Харин Монгол дахь тархацыг гаргахын тулд Б.Даваацэрэнгийн нийтэлсэн зосон зургийн бүртгэлээс (Даваацэрэн 2017) харахад “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн тархацын зүүн хязгаар нь Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн хавцгай, баруун хойд зах нь Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Тольжгий боом, баруун зах нь Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Дашлангийн голын зураг ба Бичигт Хангай уул, баруун өмнөх зах нь Өвөрхангай аймгийн Хужиртын ширээт, хойд зах нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Өгөөмөр уулын зургууд бололтой. “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн тархалтын Архангай-Өвөрхангайн баруун захын зурвасаас наад зах нь 500 км баруун тийшээ Монгол- Алтайн нурууны өмнөд биед байх Дунд Хулдын голын зосон зургийн дурсгал илэрсэн нь ийм хэлбэрийн зургийн тархалтыг үлэмж тэлж байна. Давтан хэлэхэд “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зураг Алтайгаас илэрч буй анхны тохиолдол энэ болно.

“Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн дүрүүд. Өвөр Байгал ба Монголын “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн дүрүүд онцын ялгаагүй юм. “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн зохиомж хоёр гол цөмийг тойрсон 5 үндсэн дүр ба бусад туслах дүрслэлүүдээс бүрддэг гэж тодорхойлж байна. Дүр дүрслэлүүдийг судлаачид нэлээд дээрээс тодорхойлж гаргасан байдаг (Окладников, Запорожская 1970: 64-78). Бидний хувьд гол ба бусад дүрүүд мөн зохиомжийн цөмийг ялган тодорхойлов. Эдгээр нь:

1) хамгийн гол дүрийн нэг болсон хүн, ихэвчлэн хөтлөлцөн зогссон байдалтай юм уу дөрвөлжин хашлаган дотор байгаагаар дүрслэгддэг,

2) өөр нэг гол дүр болсон амьтад, цуварсан байдалтайгаар болон хос зураасны дээр доор толгой нь өөд уруу байдалтайгаар дүрслэгддэг адуу голдуу, заримдаа буга, гахай зэрэг том туурайтан амьтад, цөөн тохиолдолд мийгийн төрлийн махчин араатан байна,

3) гуравдахь гол дүр болсон шувууд, дөрвөлжин хүрээний дээр далавчаа дэвсэн байдалтай байхаас

гадна зохиомжуудын эргэн тойронд ганцаар болон олноор дүрслэгддэг,

4) дөрөвдэх гол дүр болсон хүрээ ба доторхи цэгүүд, ихэвчлэн дөрвөлжин хүрээ байх боловч дугуй хүрээ ч тохиолддог бөгөөд дотор нь байх цэгүүд их бага тоотой байдаг нь зохиомжийн хоёр гол цөмийн нэг нь юм,

5) тав дахь гол дүр болсон хос зураас, зохиомжийн нөгөө нэг гол цөм нь гэж ойлгож болох бөгөөд энэ хос зураасны дээр доор хүмүүс ба амьтад толгой нь дээш доош харсан байдалтай зурагддаг,

6) бусад туслах дүрслэлүүд байдаг нь: хэрээс, дугуй зэрэг геометр дүрслэлүүд болон үл танигдах бусад дүрслэлүүд болно.

Дунд Хулдын зосон зурагт хүн, амьтан, хүрээ ба цэгүүд, хос зураас зэрэг гол дүрүүд байх бөгөөд зохиомжийн хос цөм мөн бүрэн байна. Үгүйлэгдэж байгаа зүйлс нь зөвхөн шувуу ба геометр дүрслэлүүд юм. Иймээс Дунд Хулдын зосон зургийн дурсгалыг “Сэлэнгийн” хэлбэрийн сонгодог хэв шинжтэй, бүрэн зохиомжтой дурсгал мөн хэмээн тодорхойлж болно.

“Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн утга агуулга. Хэдийгээр дээр дурдсанчлан Дөрвөлжин булшны соёлын хадны зосон зургийн дурсгалын утга агуулгын асуудал маргаантай байгаа боловч ерөнхийдөө ямарваа нэгэн тахил тайлгийн ёслолыг илэрхийлсэн гэдэг ерөнхий зүйл дээр санал нэгддэг байна (Амартүвшин 2002: 17). Үүний зэрэгцээ сүүлийн үед Монголын археологийн хүрээнд хамгийн нөлөөтэй байгаа үзэл бол З.Батсайхан, Ч.Амартүвшин нарын дэвшүүлсэн тавьсан “оршуулгын зан үйлийн” онол юм.

Ч.Амартүвшингийн үзэж байгаагаар бол “далавчаа дэлгэсэн шувуу, дөрвөлжин хүрээнд буй олон цэг энэ бүхнийг ямар нэгэн овог аймгийн оршуулга, тэрхүү овог аймгийг тэнгэртэй холбох зууч, хойд насны төсөөллийг илэрхийлсэн ... дөрвөлжин хүрээг тухайн овгийг ялган доторхи олон цэгийг хүрлийн үеийн тухайлсан овог аймгийнхны оршуулга-олон булш бүхий оршуулгын цогцолбор газар, хүрээний гадуурх хоорондоо хөтлөлцсөн адуу, үхэр хөтөлсөн хүмүүсийг оршуулгын зан үйлийг гүйцэтгэж байгаагаар илэрхийлсэн тэмдэглэгээ байж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн” байна (Амартүвшин 2002: 18). Харин З.Батсайхан “манай дэлхий ертөнцийг загвар, үхэл, амьдралын тухай болон түүнтэй холбоотой янз бүрийн төсөөлөл, шүтлэг бишрэл, зан заншлыг багтаасан үлэмж өргөн хүрээтэй мэдээллийг агуулсан дурсгал” гэж үзсэн байдаг (Батсайхан 2003: 34).

Дунд Хулдын зосон зурагт байх дөрвөлжин хүрээ доторхи дүрслэлүүд дотор 5 зэрэгцэн зогссон хүн ба түүний доор нэгэн хэвтээ хүний дүрслэл, гурван цэг, мөн өөр нэгэн хэвтээ хүн бололтой дүрслэл байгаа нь оршуулгын зан үйлтэй холбоотой тухай онолтой

нийцэж байна хэмээн үзэв. “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зурагт гараа алдсан зогссон хүмүүсийн дүрслэлийг хүрээний гадна болон дотор талд зурдаг уламжлалтай. Харин бидний үзсэний хэмжээнд дөрвөлжин хүрэн дотор хэвтээ байдалтай дүрсэлсэн хүний зураг одоогоор илрээгүй байна. Энэ нь тухайн зургийн уламжлалын хүрээнд ашигласан дүрслэлзүйн хэлээр хэвийн бус байдалд орсон хүн буюу өөд болсон хүнийг харуулах хэлбэр бололтой байна. Энэхүү хэвтээ хүн нь зэрэгцээ хос зураасны дээд талд хэвийн байдалтай байрласан хүн, малын дүрслэл, харин доод талд нь толгой нь уруу харсан хүн малын дүрсүүд байгааг хоршиж “амьдын ертөнц” ба “үхэгсдийн ертөнц”-ийг дүрслэн үзүүлсэн дүрслэл зүйн нэгэн ховор хувилбар чуулбар болж байна хэмээн үзэв. Ингэснээрээ “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зураг нь оршуулгын зан үйл, ертөнцийн дэг журам ба үхэл амьдралын тухай төсөөллийг илтгэсэн гүн ухааны агуулгатай гэсэн онолыг батлах нэгэн гэрч болох болов уу.

### Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Дунд Хулдын голын Чойлонгийн хадны зосон зургийн дурсгал Монгол ба Өвөр Байгалд тархсан хожуу хүрлээс түрүү төмрийн үед хамаарах Дөрвөлжин булшны соёлын “Сэлэнгийн” хэлбэрийн зургийн уламжлалд хамаарна.

“Сэлэнгийн” хэлбэрийн хадны зургийн тархалт ба байрлал зүй, үйлдсэн техник, дүр дүрслэл, утга агуулгыг хангалттай хэмжээнд тодорхойлон бичих бололцоо бүрдсэн бөгөөд өмнөх үеийн судлаачид дээрх зорилтуудыг хангалттай биелүүлж чаджээ. Гэхдээ жижиг онцлогууд, цөөн онцгой дүр ба дүрслэлүүд нэмж илэрсээр байж болохыг Дунд Хулдын зосон зургийн дурсгал харуулж байна.

Дунд Хулдын зосон зурагт хүн, амьтан, хүрээ ба цэгүүд, хос зураас зэрэг гол дүрүүд байх бөгөөд зохиомжийн хос цөм мөн бүрэн байгаа тул энэ дурсгалыг “Сэлэнгийн” хэлбэрийн сонгодог хэв шинжтэй, бүрэн зохиомжтой дурсгал мөн хэмээн тодорхойлж болно.

Энэхүү дурсгал илэрснээр “Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн тархалт баруун тийш үлэмж тэлж байгаа бөгөөд нарийвчилбал, одоогоор мэдэгдээд байгаа Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Дашлангийн голын зураг ба Бичигт Хангай уулын зургаас баруун урагш 500 км зайг тэлж байгаагаараа судалгааны ач холбогдолтой юм.

“Сэлэнгийн” хэлбэрийн зосон зургийн утга агуулгын талаарх мэтгэлцээнд Дунд Хулдын зосон зураг мөн өөрийн хувь нэмрийг оруулж чадна. Энэхүү зурагт буй дөрвөлжин хүрэн доторхи хүмүүс, ялангуяа хэвтээ байдалтай дүрсэлсэн хүний дүрслэл

нь нас барсан, өөд болсон буюу энэ ертөнцийн хэвийн байдлаас ангижирсан гэсэн санааг илэрхийлж буй дүрслэлзүйн хэллэг болох тул “Сэлэнгийн” хэлбэрийн зураг нь үхэл ба нөгөө ертөнцийг дүрсэлсэн гэсэн З.Батсайхан, Ч.Амартүвшин нарын онолыг дэмжих нэгэн гэрч баримт болох юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Дунд Хулдын голын зэргэлдээх Урд Хулдын голд манай экспедицийн 2021 онд малтсан дөрвөлжин булш хэдийгээр тоногдож сүйдсэнээс болж хүн малын яс ба эд өлгийн зүйлс гараагүй боловч бүтэц хэлбэрийн хувьд хэв шинжтэй дөрвөлжин булш байсан нь дээрх хадны зосон зурагтай хосолж нэгэн цогц болж байгаа юм. Энэхүү зураг ба булш нь Дөрвөлжин булшны соёлын тархалтыг үлэмж хэмжээгээр баруун зүгт тэлж байгаа тул НТӨ 1000-200 он буюу хожуу хүрлээс түрүү төмрийн үеийн археологийн соёлуудын тархалт ба хөдөлгөөнийг судлахад чухал эх хэрэглэгдэхүүн болно.

### Abstract

#### NEWLY FOUND SELENGE TYPE ROCK OCHRE PAINTINGS IN MONGOLIAN ALTAI (Tonkhil soum of Gobi-Altai aimag)

by Tsagaan Turbat, Ochirkhuyag Nergui and  
Byambadorj Lhagvadorj

A group of ochre paintings traditionally classified as “Selenge type” has been discovered on a small rocky promontory at Choilon ford situated in the Dund Khuld river valley in the southern slopes of the Altai mountain range, within the Tonkhil soum of Gobi-Altai province. These ochre paintings can be categorized into two distinct groups. The initial group, characterized by a pair of triangles, is associated with a particular culture for which the exact dating remains uncertain. Conversely, the second group, featuring a pair of lines, depictions of animals, humans, and a square frame, corresponds to the Slab Grave culture, attributable to the Late Bronze Age and Early Iron Age. Adjacent to these paintings are four carvings of deer, aligning with the Deer Stone Khirgisuur culture. The significance of this rock art lies in its current location at the westernmost extremity of the “Selenge type” rock paintings affiliated with the Slab Grave culture, rendering it a subject of considerable research interest.

**Keywords:** “Selenge type” rock ochre paintings, Late Bronze Age, Early Iron Age, petroglyphs, Mongolia, Altai

## Ном зүй

Ponomareva, I.A. (2020). Unraveling manifold identities in the early nomadic rock art of East Siberia. – In: Archaeological Research in Asia, Vol. 23: 100208. DOI: 10.1016/j.ara.2020.100208

Амартүвшин, Ч. (2002). “Сэлэнгийн” зосон зургийн дүрслэл оршуулгын зан үйлтэй холбогдох нь. – In: Түүхийн Сэтгүүл, Vol. III: 16–19.

Батсайхан, З. (2003). “Сэлэнгийн” хэмээх зосон зургуудыг шинээр тайлбарлах нь. – In: Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 210(19): 156–161.

Болдбаатар, Ю. (2017). Дөрвөлжин булшны хашлаганы зураг дахь бүжиг хийгээд сексийг тайлбарлах нь. in: Төв Ази ба Умард Хятадын хадны зураг. Эмхэтгэсэн Ц.Төрбат, Н.Батболд. - УБ. 158- 176.

Даваацэрэн, Б. (2017). Монголын хадны зосон зургийн судалгааны өнөөгийн тойм. in: Төв Ази ба Умард Хятадын хадны зураг. Эмхэтгэсэн Ц.Төрбат, Н.Батболд. - УБ. 212-223.

Окладников, А.П. (1949). Археологические исследования в Бурят-Монгольской АССР. – In: КСИИМК, Vol. 26: 7–11.

Окладников, А.П., Запорожская, В.Д. (1970) Петроглифы Забайкалья. Часть 2. - Л., 1970. - 262 стр.

Цыбиктаров, В.А. (2011). Петроглифы Забайкалья (формирование источниковой базы, историография и вопросы культурно-исторической интерпретации). - Улан-Удэ. - 276 стр.

